



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/126/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай хот

2022 он

Төрийн аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365

Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дагвасүрэн

Утас: 99014227

Цахим хаяг: dagvasurend@audit.gov.mn

Аудитор: Г.Баасанжаргал

Утас: 99032514

Цахим хаяг: baasanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	10
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт	11
4.2.1 Залруулсан алдаа	11
4.2.2 Төлбөрийн акт	11
4.2.3 Албан шаардлага	11
4.2.4 Зөвлөмж.....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	12
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

2022.02.22 № 1302/192
танай _____ -ны № _____ -т

БАЯНХАЙРХАН СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ч.СЭРЖМЯДАГ-Т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

013022091

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	34,045,162.00	25,203,319.00
33	АВЛАГА	6,635,699.00	978,702.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	6,635,699.00	978,702.00
35	БАРАА МАТЕРИАЛ	27,409,463.00	24,224,617.00
351	Түүхий эд материал	6,764,841.00	4,081,210.00
35110	Тусгай зориулалттай материал	6,054,841.00	3,373,000.00
35130	Эм боох материал	710,000.00	708,210.00
354	Хангамжийн материал	20,644,622.00	20,143,407.00
35410	Бичиг хэргийн материал	239,400.00	281,040.00
35420	Аж ахуйн материал	648,000.00	1,054,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	4,983,160.00	2,037,210.00
35450	Барилгын засварын материал	00.00	00.00
35460	Хүнсний материал	6,190,330.00	7,164,790.00
35470	Бусад хангамжийн материал	8,583,732.00	9,606,367.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	43,297,431.88	59,368,656.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	43,297,431.88	59,368,656.46
392	Биет хөрөнгө	34,968,056.88	51,451,781.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	14,644,527.81	14,644,527.81
39202	Хуримтлагдсан элэгдэл	-813,584.88	-1,220,377.32
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	16,330,808.00	20,877,878.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-10,325,187.11	-8,680,091.87
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,496,375.17	14,074,648.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,754,738.21	-6,746,698.33
39214	Бусад үндсэн хөрөнгө	26,041,970.00	37,019,548.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-19,630,383.90	-19,495,923.60
39217	Ном	978,270.00	978,270.00
393	Биет бус хөрөнгө	8,329,375.00	7,916,875.00
39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-240,625.00	-653,125.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,920,000.00	6,920,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	77,342,593.88	84,571,975.46
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	109,023.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	109,023.00
413	Өглөг	00.00	109,023.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	109,023.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	77,342,593.88	84,462,952.46
51	Засгийн газрын хувь оролцоо	77,342,593.88	84,462,952.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	49,446,214.00	49,446,214.00
51101	Өмч: - төрийн	49,446,214.00	49,446,214.00
512	Хуримтлагдсан үр дүн	19,136,637.51	26,256,996.09
51210	Өмнөх үеийн үр дүн	19,136,637.51	19,136,637.51
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	7,120,358.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,759,742.37	8,759,742.37
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	77,342,593.88	84,571,975.46

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	249,378,200.00	247,782,812.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,939,000.00	14,196,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,939,000.00	14,196,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,939,000.00	14,196,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,939,000.00	14,196,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,267,600.00	11,023,812.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	238,171,600.00	222,562,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	5,056,212.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	5,056,212.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	7,267,600.00	5,967,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	7,267,600.00	5,967,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	238,269,253.70	240,457,966.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	238,269,253.70	240,457,966.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	194,771,742.70	199,265,213.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	146,753,347.00	148,259,749.00
210101	Үндсэн цалин	100,106,356.00	105,956,380.00
210102	Нэмэгдэл	33,307,778.00	30,018,939.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	447,500.00	00.00
210104	Урамшуулал	12,891,713.00	12,284,430.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,698,037.00	19,745,568.00
210201	Тэтгэврийн даатгал	12,945,137.00	13,767,607.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,438,600.00	1,428,522.00
210203	ҮОМЦО-ний даатгал	1,150,300.00	1,142,837.00
210204	Ажилгүйдлийн даатгал	287,600.00	284,328.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,876,400.00	3,122,274.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,248,168.00	8,218,129.00
210301	Гэрэл, цахилгаан	176,968.00	178,679.00
210302	Түлц, халаалт	2,980,440.00	7,909,650.00
210303	Цэвэр, бохир ус	90,760.00	129,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,132,750.00	6,448,029.00
210401	Бичиг хэрэг	593,300.00	455,360.00
210402	Тээвэр, шатахуун	983,250.00	954,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	447,500.00	382,363.00
210404	Ном, хэвлэл	59,400.00	59,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,049,300.00	1,320,100.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	3,276,706.00
2105	Нормативт зардал	13,364,930.00	7,478,650.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,500.00	812,210.00
210502	Хоол, хүнс	13,327,430.00	6,666,440.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	561,400.00	561,400.00
210604	Урсгал засвар	561,400.00	561,400.00
2107	Томилолт, зочны зардал	200,000.00	364,000.00
210702	Дотоод албан томилолт	200,000.00	364,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	714,900.00	737,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	564,900.00	346,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	390,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,098,210.70	7,452,688.06
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	601,700.00	707,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	6,496,510.70	6,745,188.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,497,511.00	41,192,753.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	5,056,212.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	5,056,212.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	42,105,239.00	36,105,020.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,105,239.00	36,105,020.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	270,272.00	31,521.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	270,272.00	31,521.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,122,000.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,122,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	11,108,946.30	7,324,845.94
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	100,000.00	00.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	100,000.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,265,148.14	204,487.36
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,223,748.14	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,041,400.00	204,487.36
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-5,165,148.14	-204,487.36
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	5,943,798.16	7,120,358.58

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	20.. оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	49,446,214.00	8,759,742.37	19,136,637.51	00.00	77,342,593.88
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	49,446,214.00	8,759,742.37	19,136,637.51	00.00	77,342,593.88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	49,446,214.00	8,759,742.37	19,136,637.51	00.00	77,342,593.88
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	7,120,358.58	00.00	7,120,358.58
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	49,446,214.00	8,759,742.37	26,256,996.09	00.00	84,462,952.46

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайланг оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	119,331,000.00	119,301,473.00	239,503,700.00	192,393,459.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	119,331,000.00	119,301,473.00	239,503,700.00	192,393,459.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	119,215,900.00	119,236,473.00	239,503,700.00	192,393,459.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	81,581,000.00	81,507,845.00	158,365,400.00	142,602,752.00
210101	Үндсэн цалин	70,726,400.00	70,911,087.00	103,416,400.00	100,299,383.00
210102	Нэмэгдэл	4,537,700.00	4,319,016.00	42,363,300.00	30,018,939.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00	500,000.00	00.00
210104	Урамшуулал	6,316,900.00	6,277,742.00	12,085,700.00	12,284,430.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,149,800.00	9,197,469.00	21,379,400.00	19,636,545.00
210201	Тэтгэврийн даатгал	5,822,700.00	5,914,096.00	15,044,800.00	13,658,584.00
210202	Тэтгэмжийн даатгал	665,400.00	652,067.00	1,583,700.00	1,428,522.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	831,800.00	815,085.00	1,266,900.00	1,142,837.00
210204	Ажигүйдлийн даатгал	166,300.00	163,015.00	316,700.00	284,328.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,663,600.00	1,653,206.00	3,167,300.00	3,122,274.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,077,500.00	2,688,741.00	6,706,200.00	5,374,679.00
210301	Гэрэл, цахилгаан	740,000.00	196,041.00	1,100,000.00	178,679.00
210302	Түлш, халаалт	5,066,200.00	2,414,700.00	5,066,200.00	5,066,200.00
210303	Цэвэр, бохир ус	271,300.00	78,000.00	540,000.00	129,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	682,800.00	1,472,413.00	5,652,400.00	3,516,463.00
210401	Бичиг хэрэг	35,000.00	148,900.00	1,292,100.00	497,000.00
210402	Тээвэр, шатахуун	381,800.00	845,900.00	1,888,000.00	851,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	60,400.00	109,860.00	700,000.00	382,363.00
210404	Ном, хэвлэл	27,900.00	5,000.00	59,400.00	59,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	177,700.00	362,753.00	1,712,900.00	1,726,100.00
2105	Нормативт зардал	20,826,100.00	23,064,605.00	34,328,700.00	10,066,720.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,000.00	00.00	2,547,100.00	731,820.00
210502	Хоол, хүнс	20,589,000.00	22,957,605.00	29,987,500.00	7,540,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	210,100.00	107,000.00	1,794,100.00	1,794,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	272,600.00	158,000.00	561,400.00	561,400.00
210604	Урсгал засвар	272,600.00	158,000.00	561,400.00	561,400.00
2107	Томилдолт, зочны зардал	107,600.00	382,000.00	891,200.00	364,000.00
210701	Гадаад албан томилдолт	00.00	00.00	00.00	00.00
210702	Дотоод албан томилдолт	107,600.00	382,000.00	891,200.00	364,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,700.00	290,000.00	925,400.00	737,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	57,700.00	290,000.00	534,700.00	346,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	390,700.00	390,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	460,800.00	475,400.00	10,693,600.00	9,533,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	460,800.00	475,400.00	10,693,600.00	9,533,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,100.00	65,000.00	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	115,100.00	65,000.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	115,100.00	65,000.00	00.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	30,000.00	00.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	30,000.00	00.00	00.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	119,331,000.00	119,331,473.00	239,503,700.00	192,393,459.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	119,231,000.00	119,231,473.00	232,236,100.00	186,457,380.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	119,231,000.00	119,231,000.00	232,236,100.00	186,457,380.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	00.00	473.00	00.00	00.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	7,267,600.00	5,936,079.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	00.00	7,267,600.00	5,936,079.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	100,000.00	100,000.00	00.00	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	14.00	15.00	14.00	15.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	09.00	08.00	09.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	05.00	05.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	245,439,200.00	233,586,212.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	245,439,200.00	233,586,212.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	238,171,600.00	222,562,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	5,056,212.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	5,056,212.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	7,267,600.00	5,967,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	7,267,600.00	5,967,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	243,789,200.00	224,583,312.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	243,789,200.00	224,583,312.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	200,291,689.00	183,390,559.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	153,389,046.00	142,602,752.00
210101	Үндсэн цалин	106,742,055.00	100,299,383.00
210102	Нэмэгдэл	33,307,778.00	30,018,939.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	447,500.00	00.00
210104	Урамшуулал	12,891,713.00	12,284,430.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,696,465.00	19,636,545.00
210201	Тэтгэврийн даатгал	12,943,565.00	13,658,584.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,438,600.00	1,428,522.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,150,300.00	1,142,837.00
210204	Ажилгүйдлийн даатгал	287,600.00	284,328.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,876,400.00	3,122,274.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,313,928.00	5,374,679.00
210301	Гэрэл, цахилгаан	176,968.00	178,679.00
210302	Түлш, халаалт	5,046,200.00	5,066,200.00
210303	Цэвэр, бохир ус	90,760.00	129,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,466,750.00	3,516,463.00
210401	Бичиг хэрэг	586,300.00	497,000.00
210402	Тээвэр, шатахуун	952,750.00	851,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	700,000.00	382,363.00
210404	Ном, хэвлэл	59,400.00	59,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,168,300.00	1,726,100.00
2105	Нормативт зардал	15,473,100.00	10,066,720.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	765,500.00	731,820.00
210502	Хоол, хүнс	13,513,600.00	7,540,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн элдэл	1,194,000.00	1,794,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	561,400.00	561,400.00
210604	Урсгал засвар	561,400.00	561,400.00
2107	Томилолт, зочны зардал	200,000.00	364,000.00
210702	Дотоод албан томилолт	200,000.00	364,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	406,900.00	737,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	256,900.00	346,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	390,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,784,100.00	531,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,784,100.00	531,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,497,511.00	41,192,753.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	5,056,212.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	5,056,212.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	42,105,239.00	36,105,020.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,105,239.00	36,105,020.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	270,272.00	31,521.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	270,272.00	31,521.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,122,000.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,122,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,650,000.00	9,002,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,650,000.00	9,002,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,650,000.00	9,002,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,650,000.00	9,002,900.00
222001	Тоног төхөөрөмж	00.00	8,002,900.00
223001	Бусад хөрөнгө	1,650,000.00	1,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1,650,000.00	-9,002,900.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		5,056,212.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		5,056,212.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	5056212.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		5,056,212.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		5,056,212.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	5056212.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		5,056,212.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		5,056,212.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Г.Баасанжаргал гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн сургуулийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар товч тодорхойллоо. Үүнд:

Зорилго: Бага насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх
Зорилт: Сургалтын эрүүл аюулгүй, тохилог таатай орчинд ардын уламжлалт тоглоом наадгайгаар дамжуулан хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлж хамтын ажиллагааг чанаржуулах

Чиглэл: Сургуулийн өмнөх боловсрол олгох

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 247,782.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,477.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 1,610.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	6,635.70	978.70	(5,657.00)
Бараа материал	27,409.40	24,224.60	(3,184.80)
Үндсэн хөрөнгө	43,297.40	59,368.60	16,071.20
Нийт хөрөнгө	77,342.50	84,571.90	7,229.40
Өр төлбөр	-	109.00	109.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	77,342.50	84,462.90	7,120.40
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	77,342.50	84,571.90	7,229.40

Авлага дансны үлдэгдэл 5,657.0 мянган төгрөгөөр буурсан нь ажиллагсадтай холбоотой авлага барагдсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 3,184.8 мянган төгрөгөөр буурсан нь материалын худалдан авалт бага байсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 16,071.2 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар ирсэн бусад үндсэн хөрөнгө болон хуримтлагдсан элэгдлийн зардалтай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 109.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд ажиллагсадтай холбоотой нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,120.0 мянган төгрөг болж өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалж байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 244,559.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 244,559.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 222,562.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 5,967.6 мянган төгрөг, нэмэлтээр 5,056.2 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус авч, урсгал үйл ажиллагаанд 224,583.3 мянган төгрөгийг зарцуулж, 36,105.0 мянган төгрөгийг улсын төсөвт, 31.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 5,056.2 мянган төгрөгийн санхүүжилт авч 5,056.2 мянган төгрөгийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж олгосон байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн анхан шатны баримтын бүрдүүлэлт сайн, Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн цагалбар, болон НББ-ийн тухай хууль, Сангийн сайдын 388 дугаар тушаалын дагуу бэлтгэсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Төсвийн тухай хууль болон НББ-ийн тухай хууль бусад заавар журмыг дагаж мөрдсөн байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 149 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар авлагыг барагдуулах зөвлөмж өгснийг тайлант онд барагдуулан ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,650.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,650.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.2.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулгын алдаа гараагүй болно.

4.2.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.2.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

2020 онд “Си-Ти-Эс” ХХК-аас нийлүүлэгдсэн 1,650.0 мянган төгрөгөөр худалдан авсан санхүүгийн программыг одоог хүртэл ашиглаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, УСНББОУС 17-той нийцэхгүй бөгөөд тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

“Си-Ти-Эс” ХХК-аас нийлүүлэгдсэн 1,650.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн програмыг 2022 оны 03 дугаар сарын 01-ээс ашиглаж эхлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян.төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
		1	1,650.0							1	1,650.0
	Дүн	1	1,650.0							1	1,650.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Дүн										
	Нийт дүн										

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА 2022.02.21

АХЛАХ АУДИТОР Б.ДАГВАСҮРЭН 2022.02.21

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР Г.БААСАНЖАРГАЛ 2022.02.21